



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

МӨНГӨ, САНХҮҮГИЙН СТАТИСТИК


Танилцуулга
2018 оны 8 дугаар сар

Улаанбаатар
2018

1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар өсч 17.4 их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн 13.4 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 3.1 нэгж хувийг төгрөгийн харилцах, 3.5 нэгж хувийг валютын харилцах, хадгаламж бүрдүүлсэн байна. Харин төгрөгийн хадгаламжийн дийлэнх хувийг буюу 86 хувийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна.

Мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үеэс 20.1%-иар өсч, жилийн өсөлтийн хурд саарч байна.




Өмнөх сартай харьцуулахад мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдээс валютын хадгаламж буурч бусад бүрэлдэхүүн хэсгүүд өссөнөөр нийт дүнгээр 229.2 тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнээс төгрөгийн болон валютын харилцахын өсөлтийг байгууллагуудын харилцахын өсөлт тайлбарлаж байгаа бол төгрөгийн хадгаламжийн хувьд иргэд, санхүүгийн байгууллага, улсын байгууллагын хадгаламж нэмэгдсэн байна.

M2 өмнөх сараас 229.2 тэрбум төгрөгөөр өсөв.




Нийт хадгаламжийн хэмжээ 12 их наяд төгрөгт хүрснээс 83 хувь буюу 10 их наяд төгрөг нь иргэдийн, 17 хувь буюу 2 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Нийт хадгаламжийн 22 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байгаагаас иргэдийн хадгаламжийн 19.0 хувийг, байгууллагын хадгаламжийн 36.2 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлжээ.

Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 22%-иар өсч 12 их наяд төгрөгт хүрчээ.



M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн 18.6 их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн -1.4 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал M2 мөнгөний өсөлтийн 16 нэгж хувийг ГЦА-ын өсөлт, үлдсэн 4 нэгж хувийг ДЦА-ын өсөлт бүрдүүлжээ. ГЦА-ын өсөлтийг Төв Банкны ГЦА буюу гадаад валютын улсын нөөцийн өсөлт бүрүүлж байгаа бол ДЦА-ын өсөлтийг дотоод зээлийн өсөлт бүрдүүлж байна.


M2 мөнгөний жилийн өсөлтийн дийлэнх хэсгийн ГЦА-ын өсөлт бүрдүүлж байна.



2. БАНКУУДЫН ЗЭЭЛ

Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 20.1 хувиар, үүнээс иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 23.8 хувиар өсч 7.9 их наяд төгрөгт, хувийн байгууллагынх 16.7 хувиар өсч 7.8 их наяд төгрөгт тус тус хүрчээ.


Нийт зээлийн үлдэгдэл 15.8 их наяд ₮ -т хүрч, жилийн 20.1%-иар өсөв.



Нийт зээлийн үлдэгдлийн 21.0 хувь буюу 3.3 их наяд төгрөг нь валютын зээл байна. Тодруулбал иргэдийн зээлийн 2.0 хувь нь, хувийн байгууллагын 40.3 хувь нь гадаад валютын зээл байна.


Тайлант сард шинээр олгосон зээл өмнөх сараас 398.1 тэрбум төгрөгөөр, эргэн төлөгдсөн зээл 181.7 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ. Олгосон зээлийн 16.2 хувь буюу 316.3 тэрбум төгрөгийг гадаад валютаар олгожээ.

Тайлант сард 1954.4 тэрбум ₮-ийн зээл олгогдож, 1556.3 тэрбум ₮ эргэн төлөгдлөө.




Өмнөх сартай харьцуулахад иргэдэд олгосон зээл 288.6 тэрбум төгрөгөөр, хувийн байгууллагад олгосон зээл 104.3 тэрбум төгрөгөөр, иргэдийн зээлийн эргэн төлөлт 64.2 тэрбум төгрөгөөр, хувийн байгууллагын зээлийн эргэн төлөлт 112.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хувийн байгууллагад олгосон зээлийн бүтэц



Тайлант сард хувийн байгууллагад 824.2 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 36.3 хувь буюу 299.0 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Худалдаа, уул уурхай, боловсруулах болон барилгын салбарт дийлэнх зээл олгогдсон байна.


Иргэдэд олгосон зээлийн бүтэц



Тайлант сард иргэдэд 1,094.1 тэрбум төгрөгийн зээл олгогдсоны 1.6 хувь буюу 17.2 тэрбум төгрөгийн зээл гадаад валютаар олгогджээ. Иргэдэд олгосон зээлийн дийлэнх буюу 68.6 хувийг цалин тэтгэвэр, хадгаламж барьцаалсан, картын болон автомашины зээл бүрдүүлсэн байна. Үүний дараагаар олгосон зээлийн 7 хувь уул уурхай, 5 хувь худалдаа, 5 хувь үл хөдлөх хөрөнгийн салбарт тус тус олгогджээ.

Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл 1,359.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх сартай харьцуулахад 35.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Чанаргүй зээлийн 22.8 хувийг боловруулах, 18.0 хувийг уул уурхай, 14.0 хувийг барилга, 12.1 хувийг худалдааны салбарт олгосон зээл эзэлж байна. Нийт чанаргүй зээлийн 75.0 хувь нь төгрөгөөр олгосон зээл байна.


Нийт чанаргүй зээлийн 82.9 хувь нь хувийн байгууллагад, 16.3 хувь нь иргэдэд ноогдож байна.



Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл өмнөх сараас 86.7 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Тайлант сард барилгын салбарын зээл 180.1 тэрбум төгрөг, худалдааны салбарын зээл 38.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол бусад салбарын зээл 113.7 тэрбум төгрөг, боловсруулах салбарын зээл 20.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.


Өмнөх сартай харьцуулахад чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь хэвэндээ буюу 3 сар дараалан 8.6 хувь байгаа бол хугацаа хэтэрсэн зээлийнх 0.3 нэгж хувиар буурсан байна. Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 82.9 хувийг, чанаргүй зээлийн 82.6 хувийг хувийн байгууллагын зээл бүрдүүлж байна.

Чанаргүй зээл нийт зээлийн 8.6%, Хугацаа хэтэрсэн зээл 6.4% байна.




Иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 249.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс, цалин, тэтгэврийн зээл 197.4 тэрбум төгрөг, хадгаламж барьцаалсан зээл 28.3 тэрбум төгрөг, автомашины зээл 18.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн бол үл хөдлөх хөрөнгийн зээл 79.6 тэрбум төгрөгөөр буурчээ.


Хувийн байгууллагын зээлийн үлдэгдлийн дийлэнх хувийг уул уурхай, худалдаа, боловсруулах болон барилгын салбарын зээл бүрдүүлж байна.



Иргэдийн зээлийн 41.2 хувийг орон сууцны зээл (МИК-д шилжүүлсэн багцыг оруулснаар) бүрдүүлж байна.



ЖДҮ-ийн зээлийн дийлэнх хувийг худалдаа, боловсруулах, барилгын салбар болон бусад салбарын зээл эзэлж байна.




ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдэл 3.17 их наяд төгрөгт хүрснээс 28.7 хувийг худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 18.4 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 13.0 хувийг барилгийн салбарт олгосон байна. ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 4.0 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 11.4 хувь нь чанаргүй зээлд ангилагдсан байна.

3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ


Ипотекийн зээлийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөгт, зээлдэгчдийн тоо 94,224-т хүрчээ. Үүнээс хөтөлбөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн үлдэгдэл 3.3 их наяд төгрөгт, зээлдэгчдийн тоо 69,585-т хүрсэн байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 75.8 хувь нь 8 хувийн хүүтэй хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл, 21.8 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, 2.3 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх оноос 3.5 хувиар өсчээ.



Нийт ипотекийн зээлийн 75.8 хувь нь хөтөлбөрийн зээл байна.



Орон нутгийн ипотекийн зээл¹-ийн 77.4 хувь нь хөтөлбөрийн зээл, 21.7 хувь нь өөрийн эх үүсвэрээр, 0.8 нь бусад эх үүсвэрээр олгогджээ.


Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 17.5 хувь нь орон нутагт байршилтай орон сууц худалдан авахад олгожээ.



Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 95.7 хувь нь хэвийн, 2.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 1.8 хувь нь чанаргүй зээл байна.

Нийт зээлийн 921.8 тэрбум төгрөг буюу 21.2 хувь нь орон нутаг дахь банкны салбараас олгосон зээл байгаа бол худалдан авсан орон сууцны байршлаар нь авч үзвэл нийт зээлийн 759.3 тэрбум төгрөг буюу 17.5 хувь нь орон нутагт ногдож байна.

Ипотекийн зээлийн 82.5 хувь нь Улаанбаатар хотод байршилтай орон сууц худалдан авахад зарцуулагджээ.



Тайлант сард 54.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноос 38.6 хувь нь хөтөлбөрийн хүрээнд, 61.4 хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байна.

¹ Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

Ипотекийн хугацаа хэтэрсэн зээл өссөн бол чанаргүй зээл буурсан үзүүлэлттэй байна.



Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн 63.8 хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 34.3 хувийг 8 хувийн хүүтэй хөтөлбөрийн зээл, 1.9 хувийг бусад эх үүсвэрийн зээл эзэлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийн 90.4 хувь буюу 3.9 тэрбум төгрөг 80м2 хүртэлх талбай бүхий орон сууц худалдан авахад зарцуулагджээ.

Нийт ипотекийн зээл авсан зээлдэгчдийн 80.3 хувь нь 25-45 насны иргэд байгаа бөгөөд эдгээр зээлдэгчид нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 80.3 хувийг эзэмшиж байна.

Тайлант сард шинээр 804 зээлдэгчдэд ипотекийн зээл шинээр олгожээ.



Тайлант сард ипотекийн зээлтэй нийт зээлдэгчдийн тоо 94,224 байгаагийн 63.5 хувь нь 2 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой зээлдэгчид байна.

Ипотекийн зээлийн дундаж хүү өмнөх сараас 0.5 нэгж хувиар өсчээ.



4. ТӨГРӨГИЙН ГАДААД ВАЛЮТТАЙ ХАРЬЦАХ ХАНШ

Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах ханш аажмаар суларсаар сарын эцсийн байдлаар 2473.4 төгрөгт хүрсэн нь өмнөх сарын эцсээс 0.4 хувиар суларсан үзүүлэлт байна. Тайлант сарын дундаж ханш нь 2464.1 төгрөг байсан нь өмнөх сарын түвшинд байна.

Харин төгрөгийн юаньтай харьцах дундаж ханш өмнөх сараас 1.9 хувиар чангарч 359.6 төгрөг байв. Тухайн сарын хамгийн бага ханш нь 356.3 төгрөг байсан бол хамгийн өндөр ханш нь 363.0 төгрөг байлаа.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сулав.




Төгрөгийн ханш юаны эсрэг чангарсан байна.



5. ХҮҮ


Шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 2018 оны 8 дугаар сарын байдлаар төгрөгийн хадгаламжийн хувьд жилийн 12.1 хувь, валютын хадгаламжийн хувьд 5.0 хувьтай байсан нь өмнөх сараас харгалзан 1.4, 0.6 нэгж хувиар өсчээ. Тодруулбал, иргэдээс татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ 12.7 хувь, гадаад валютын ЖДХ 5.3 хувь, хувийн байгууллаас татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ 10.7 хувь, гадаад валютын ЖДХ 4.3 хувь байв.

Шинээр татсан нийт хадгаламжийн хэмжээ, хүү




Тайлант сард банкуудаас шинээр олгосон зээлийн ЖДХ төгрөгийн зээлийн хувьд 18.1 хувь, гадаад валютын зээлийн хувьд 10.2 хувьтай байгаа нь өмнөх сараас харгалзан 0.3, 0.1 нэгж хувиар өссөн байна. Үүнээс иргэдэд төгрөгөөр олгосон зээлийн ЖДХ 18.7 хувь, гадаад валютаар олгосон зээлийн ЖДХ 9.2 хувь, хувийн байгууллагад төгрөгөөр олгосон зээлийн ЖДХ 17.3 хувь, гадаад валютаар олгосон зээлийн ЖДХ 10.3 хувьтай байна.

Шинээр олгосон нийт зээлийн хэмжээ, хүү




Тайлант сард шинээр татсан нийт төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 12.1 хувьтай байна. Тайлант сард татсан хадгаламжийн дийлэнхийг 7-9 хувь ба түүнээс дээш 12-15 хувьтай татсан байна.

Шинээр татсан нийт ₮-ийн хадгаламжийн хүүний тархалт




Тухайн сард шинээр олгосон нийт төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 18.1 хувьтай байна. Тухайн сард шинээр олгосон зээлийн дийлэнхийг 18 хувь болон түүнээс дээш 19-20, 22-24 хувьтай олгогдсон байна.

Шинээр олгосон нийт ₮-ийн зээлийн хүүний тархалт



Тайлант сард шинээр татсан нийт төгрөгийн 1 жил хүртэл хугацаатай хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 12.0 хувьтай байна. Эдгээр хадгаламжийн дийлэнхийг 12-15 хувьтай татсан байна.

Шинээр татсан нийт ₮-ийн хадгаламжийн хүүний тархалт, 1 жил хүртэлх хадгаламж



Үүнээс 15 хувьтай татсан хадгаламж хамгийн өндөр буюу 170 тэрбум орчим төгрөг байна. Харин 1 жилээс 2 жил хүртэл хугацаатай хадгаламжийн хувьд ЖДХ нь 14.6 хувьтай байна.


Шинээр олгосон нийт ₮-ийн зээлийн хүүний тархалт, 1-2 жил хадгаламж




Төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 2018 оны 8 дугаар сарын байдлаар жилийн 12.3 хувь байна. Гадаад валютын хадгаламжийн үлдэгдлээр ЖДХ 5.1 хувьтай байна. Тайлант сард иргэдийн хадгаламжийн үлдэгдлээрх ЖДХ 12.3 хувь буюу өмнөх сарын түвшинд хэвээр байв. Харин хувийн байгууллагын хадгаламжийн ЖДХ төгрөгийн хадгаламжийн хувьд 11.0 хувь, гадаад валютын хувьд 5.3 хувьтай байна.

Төгрөгийн зээлийн үлдэгдлээр жигнэсэн ЖДХ 17.6 хувь, гадаад валютын зээлийн үлдэгдлээр ЖДХ 10.6 хувьтай байна. Үүнээс иргэдийн зээлийн үлдэгдлээр жигнэсэн ЖДХ төгрөгийн зээлийн хувьд 18.7 хувь, гадаад валютын зээлийн хувьд 13.0 хувьтай байна. Хувийн байгууллагын төгрөгийн зээлийн хувьд ЖДХ 15.8 хувь, гадаад валютын зээлийн хувьд ЖДХ 10.5 хувьтай байна. Нийт төгрөгийн зээлийн ЖДХ 1 дүгээр улирлаас 0.5 нэгж хувиар, гадаад валютын зээлийн ЖДХ 0.4 нэгж хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү



Нийт зээлийн үлдэгдэл, хүү




Нийт төгрөгийн хадгаламжийн үлдэгдлээр жигнэсэн дундаж хүү (ЖДХ) тайлант сарын байдлаар 12.3 хувьтай байна. Хадгаламжийн үлдэгдлийн дийлэнх нь 13-16 хувийн хүүтэй байна.

Нийт төгрөгийн зээлийн үлдэгдлээр ЖДХ тайлант сарын байдлаар 17.6 хувьтай байна. Зээлийн үлдэгдлийн дийлэнх 18 хувь ба түүнээс дээш 19-20, 22-24 хувьтай олгогджээ.

Нийт ₮-ийн хадгаламжийн үлдэгдлийн хүүний тархалт



Нийт ₮-ийн зээлийн үлдэгдлийн хүүний тархалт



6. ИНФЛЯЦИ

Тайлант сард Улаанбаатар хотын жилийн инфляци 6.4 хувьд хүрч өмнөх сараас буурсан байна. Үүнээс 5.0 нэгж хувийг хүнснээс бусад бараа, 1.4 нэгж хувийг хүнсний барааны үнийн өсөлт бүрдүүлж байна. Хүнснээс бусад барааны үнэд хатуу түлш, автобензин, тамхи болон их дээд сургуулийн үнийн өсөлт, харин хүнсний барааны бүлгийн үнэд хонь, үхрийн мах, цэцгийн тосны үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

УБ хотын хэмжээнд сарын инфляци -0.9 хувьд хүрсэн байна. Өмнөх сараас үнийн түвшин буурахад хүнсний бараа -1.4 нэгж хувийг, хүнснээс бусад бараа 0.5 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Хүнсний барааны үнэ буурахад хүнсний ногооны үнийн бууралт болон хонины махны үнийн бууралт голлон бүрдүүлж байгаа бол хүнснээс бусад бараа өсөхөд боловсролын үйлчилгээний үнийн өсөлт нөлөөлжээ.

УБ хотын жилийн инфляци 6.4 хувь




УБ хотын сарын инфляци -0.9 хувь




ХАВСРАЛТ 1. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

Зураг 1.1. М2 Мөнгөний сарын өсөлтийн бүтэц




Зураг 1.2. Нөөц мөнгөний бүтэц




ХАВСРАЛТ 2. ЗЭЭЛ

Зураг 2.1. Зээлийн үлдэгдэл, жилийн өсөлт




Зураг 2.2. Зээлийн жилийн өсөлтийн задаргаа /гол салбараар/




Зураг 2.3. Тайланд сард шинээр олгосон болон төлөгдсөн зээл




Зураг 2.4. Тайланд сард шинээр олгосон зээл (салбараар)




Зураг 2.5. Чанаргүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл




Зураг 2.6. Чанаргүй зээлийн дүн




Зураг 2.7. ЖДҮ эрхлэх зориулалтаар олгосон зээлийн үлдэгдэл




Зураг 2.8. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь, салбараар




Зураг 2.9 Хувийн байгууллагад олгосон зээлийн бүтэц /хувиар/




Зураг 2.10 Иргэдийн зээлийн жилийн өсөлтийн задаргаа




Зураг 2.11. Орон нутгийн зээлийн үлдэгдэл



Зураг 2.12. Орон нутгийн зээлийн үлдэгдэл дэх чанаргүй зээл



Зураг 2.13. Олгосон, төлөгдсөн зээл, зээлдэгчдийн тоо



ХАВСРАЛТ 3. ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр




Зураг 3.2. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, аймгуудаар




Зураг 3.3. Улаанбаатар хотын ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.4. Орон нутгийн ипотекийн зээлийн үлдэгдэл, худалдан авсан орон сууцны байршлаар




Зураг 3.5. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн ашиглалтанд орсон он



Зураг 3.7 Ипотекийн зээл авсан зээлдэгчийн орлогын тархалт



Зураг 3.6. Ипотекийн зээлийн барьцаа хөрөнгийн талбайн хэмжээ



Зураг 3.8. Ипотекийн зээл авсан зээлдэгчийн насны ангиллаарх зээлийн үлдэгдэл

